



## Гаалийн Эрсдэлийн Удирдлага



Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын зарчим нь үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх үүргийг тэнцвэртэйгээр хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх юм.



### Гаалийн байгууллага нь:

- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих;
- Гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах;
- Эрсдэл тооцох системд үндэслэсэн гаалийн хяналтын стратегийг тодорхойлно.

*Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хяналт хийх төлөв нь эрсдэлийн удирдлагын програмд урьдчилан оруулсан шалгуурын үндсэн дээр улаан, улбар шар, ногоон өнгөөр илэрхийлэгдэнэ.*

### Эрсдэл тооцох системд суурилсан гаалийн шалгалтын түвшин



### Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж /Authorized economic operator/

Итгэмжлэгдсэн Аж Ахуйн Нэгжийн хөтөлбөр гэдэг нь гаалийн байгууллага, гадаад худалдааны аюулгүй байдлыг хангах, худалдааг хөнгөвчлөх, гааль- бизнесийн түншлэлийг хөгжүүлэх зорилгоор гадаад худалдаанд оролцогчдод тодорхой шалгуур тавьж, хангасан тохиолдолд хөнгөлөлт үзүүлэх, харилцан итгэлцэлд суурилсан үйл ажиллагаа юм. Дараах үндсэн дөрвөн шалгуур үзүүлэлтийг хангасан хуулийн этгээдэд гаалийн итгэмжлэл олгоно:

1. Хууль сахиалтын түвшин сайн гэж тогтоогдсон байх
2. Хуулийн этгээдийн үйл ажиллагааны дотоод хяналт сайн байх;
3. Санхүүгийн чадавхитай байх;
4. Тогтоосон хэмжээний аюулгүй байдлын стандартыг хэлбэрэлтгүй сахих.

### Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид дараах хөнгөлөлт үзүүлнэ:

- Гаалийн бүрдүүлэлтийг хөнгөн, шуурхай хийх;
- Барааг ИААН-ийн өөрийнх нь агуулахад түр хадгалахыг зөвшөөрөх;
- Байр, агуулахад гаалийн бүрдүүлэлт хийх;
- Цахим, цаасгүй бүрдүүлэлт;
- Барааг ИААН-ийн өөрийнх нь агуулахад шалгах;
- Онцгой тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг бичиг баримтын болон биет шалгалтаас чөлөөлөх;
- Зарим тохиолдолд барааг тогтмол хугацаагаар мэдүүлэхийг зөвшөөрөх;
- ИААН нь худалдааны найдвартай түнш гэдгийг нийтэд зарлан мэдээлэх;
- ИААН-ийн хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Хэлэлцээр байгуулсан улсуудад давхар хөнгөлөлт эдлэх;
- Гаалийн байгууллагаас албан тушаалтан томилох;
- ИААН-ийн байр агуулах, талбайд барааг боловсруулалт хийх гаалийн горимын хэрэгжүүлэх;
- Гаалийн болон бусад татвар төлөлтийг хойшлуулах;
- Өрсөлдөхүйц, нэр хүндийн баталгаа;
- Компанийн дотоод үйл ажиллагаа сайжирна.

## Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны дэс дараалал:

Эрсдэлийн удирдлага нь мэдээллийг цуглуулж, боловсруулж, хууль бус үйлдлийг онилж, шалгах замаар гаалийн байгууллагын хязгаарлагдмал нөөцийг зөв оновчтой хуваарилна.



**Эрсдэлийн удирдлага нь:**  
 - зөвхөн эрсдэл бүхий ачилтыг оновчтой онилох;  
 - хууль ёсны худалдааг дэмжиж, хурдан шуурхай үйлчлэх;  
 - нийгэм, эдийн засаг, санхүүгийн аюулгүй байдлыг хамгаална.

Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд эрсдэл тооцсоны үндсэн дээр **гаалийн шалгалтын түвшинг тодорхойлно.**



**Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлснээр** гаалийн хяналтыг хэзээ, хаана, хэрхэн зохион байгуулахаа тодорхойлж, хууль бус үйлдэлд үр дүнтэй хариу үйлдэл хийх боломжийг бүрдүүлнэ.

## Эрсдэлийн удирдлагын үндсэн дөрвөн зарчим:



Гаалийн хяналтыг урьдчилан тооцох



Олон талт хамтын ажиллагааг дэмжих



Харилцан уялдаа холбоо, үр дүнг тооцсон хамтарсан хяналт, шалгалтыг зохион байгуулах



Гаалийн байгууллагын нөөц бололцоог үр дүнтэй, зөв хуваарилах

## Эрсдэлийн Удирдлага: Зөв онилгоо, оновчтой шийдэл

- Бодит, үнэн зөв мэдээлэлд суурилсан эрсдэл тооцох аргыг удирдлага болгох;  
 - Байгууллагын бүх үе шатанд эрсдэл тооцох;  
 - Гаалийн газар хороод эрсдэлт бүлгийг зөв онилж, үр дүнг тооцох.



## Холбоо барих:

Сүхбаатар дүүрэг, “Их тойруу 81/1”, Улаанбаатар хот 210620, ГЕГазар, 201 тоот, Гаалийн Эрсдэлийн Удирдлагын Хэлтэс



[www.customs.gov.mn](http://www.customs.gov.mn)



[riskmanagement@customs.gov.mn](mailto:riskmanagement@customs.gov.mn)

Утас: 70130070

Факс: 976-11-350060

## Үндсэн зорилт:

